

Аж Ахуйн тооцоон дээр ажиллах Авто Бааз

1925-12-11-нд Улсын 2 дугаар Их хурлаар хотын захиргааны дүрэм дөчин есөн зүйлийг баталсан байна.

Хотын захиргааны гүйцэтгэх газар нь долоон тэргүүлэгчидтэй, түүний дарга, орлогч, нарийн бичгийн дарга нар нь товчоо болон бүрэлдэж байсан бөгөөд хэлтсүүд нь Ерөнхий хэлтэс, Ардыг гэгээрүүлэх хэлтэс, Ардын эрүүлийг сахих хэлтэс, Аж үйлдвэрийн хэлтэс /энэхүү хэлтэст санхүү, аж ахуй, тоо бүртгэх салбарууд хамаарагдаж байв/-тэй байхаар заажээ. Хэлтсүүд нь тухайн үеийн байдлаас өөрчлөгдөж байжээ. Албан газар, цэрэг, үйлдвэрийн хэлтсүүдтэй болсон байна.

1925 онд хотын захиргаа нь 6 хэлтэс, 104 орон тоотой байв.

Улсын 2 дугаар их хурлын шийдвэр болон Засгийн газрын 22 дугаар хурлын 7-р зүйлийг үндэслэн 1926-9-3-нд Засгийн газрын 35 дугаар хурлын 12 дугаар зүйлээр 1927-1-1-нээс эхлэн хотын захиргааны газрыг Дотоод яамны харьяанаас өөрчилж тусгай эрхтэй биеэ даасан газар болгохоор заажээ.

1930 онд батлагдсан Улаанбаатар хотын захиргааны дүрмийг шинэчлэн баталж, эл дүрэмд хотын захиргаа нь Сайд нарын Зөвлөлийн шууд харьяалалд засаг захиргааны нэгж болохыг заасан

- 1931 оны 9 дугаар сарын 21-нд Улаанбаатар хотын тэргүүлэгчид, Засгийн газрын хамтарсан хурлаар, Төв аймаг, Улаанбаатар хотын захиргаа, нутаг дэвсгэрийг нэгтгэн төвлөрүүлж, “Улаанбаатар” хэмээх аймгийн захиргаа байгуулах, сонгуулийг мөн оны 10 дугаар сарын 1-нд хийхээр тогтоожээ.
- 1932 оны 10 сард Улаанбаатар хотын захиргааг Төв аймагтай нэгтгэж Улаанбаатар аймгийн Захиргаа болгосон.
- 1937 оны 2 дугаар сарын 13-нд Улаанбаатар хотын тэргүүлэгчид, СнЗ-ийн хамтарсан 4/2 дугаар тогтоолоор хотын захиргааг өөрчлөн “Нийслэл Улаанбаатар хотыг захирах яам” болгохоор тогтоосон байна.

1937 оны 2 сарын 5-нд СнЗ-ийн тогтоолоор Улаанбаатар хотын Захиргааны эрхийг өргөтгөн яамны эрх хэмжээнд хүргэж, хотыг захирах яам хэмээн нэрлэж яамны даргыг СнЗ-ийн жинхэнэ гишүүн болгожээ.

1937 оны 05 дугаар сарын 4-нд Улсын бага хурлын тэргүүлэгчдийн хурлаар Нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталсан ба үндсэн хуулийн дагуу нийслэл хотын яам нь хотын ба хороодын хуралаар батлагдахаар заажээ.

1937 оны 02 дугаар сарын 13-нд Сайд нарын Зөвлөлийн 2 дугаар хурал, Улаанбаатар хотын Тэргүүлэгчдийн 4 дүгээр тогтоолоор 02 зүйлээр Улаанбаатар хотын захиргааг өөрчлөн "Улаанбаатар хотыг захирах яам" болгосон.

1937-4-23-нд Сайд нарын Зөвлөлийн 12 дугаар хурлын 4-р зүйлээр Нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталжээ.

1937-5-4-нд УБХ-ын тэргүүлэгчдийн хурлаар нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталжээ.

1938 оны 04 дүгээр сарын 1-нд СнЗ-ийн хуралаар хот сайжруулах комиссын төслийг хэлэлцээд баталсан.

1939 оны 3 сард улсын 22 дугаар бага хурлын тогтоолоор “хотыг захирах яам” хэмээн нэрлэхийг “Улаанбаатар хотын захиргаа” хэмээн нэрлэх болсон.

1940 онд батлагдсан БНМАУ-ын үндсэн хуулиар “Улаанбаатар хотын бага хурлын тэргүүлэгчид” хэмээн тогтоосон.

1940-10-3-нд Сайд нарын Зөвлөлийн 50-р хурлын 8-р зүйлээр Улаанбаатар хотын хөдөлмөрчин ардын хурал ба хотын захиргааны дүрмийг баталжээ.

1956-7-23-нд Сайд нарын Зөвлөлийн 355-р тогтоолоор Улаанбаатар хотын захиргааны харьяанд **аж ахуйн тооцоон дээр ажиллах авто баазыг** байгуулжээ.

1960-2-12-нд т Сайд нарын Зөвлөлийн 54-р тогтоолоор Улаанбаатар хотын захиргааны харьяанд байгаа **олон жижиг баазуудыг** 1960-3-1-нээс нэгтгэж.

-Хотын худалдаа, нийтийнхоолны трестүүдийн авто бааз

Хотын нийгэм хангамжийн үйлчилгээний авто бааз болгон байгуулжээ. Богинын тээврийн авто баазыг 1960-2-15-наас Улаанбаатар хотын захиргааны харьяанд байгуулахаар тогтоожээ.

1961-6-21-нд Сайд нарын Зөвлөлийн 327-р тогтоолоор Улаанбаатар хотод 300 морин тэрэгтэй, **морин тээврийн баазыг** 1961-8-1-нээс байгуулахыг Улаанбаатар хотын захиргаанд зөвшөөрчээ.

1963-7-1-нд сайд нарын Зөвлөлийн 318-дугаар тогтоолоор Улсын барилга эдийн засгийн комиссын ерөнхий захилагчийн газар татан буугдаж байгаатай холбогдуулан “Алтай” зочид буудал мэргэжилтний орон сууцны захиргаа, үйлчилгээний авто баазуудыг нэгтгэж **аж ахуйн тооцоотой мэргэжилтнийг үйлчлэх газрыг** байгуулахаар тогтоожэб

1964-11-24-нд Сайд нарын Зөвлөлийн 601-р тогтоолоор **Нийгэм хангамжийн газрыг** өргөтгөж, богины тээврийн баазыг **нийгэм хангамжийн** авто баазад нэгтгэх.